



МОНГОЛ ДААТГАЛ ХК

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2024 ОН**

1. Үнэлгээний зорилго

1.1. Энэхүү үнэлгээний зорилго нь “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэх, компанийн засаглалын тогтолцоонд тулгарч буй асуудлыг тодорхойлох, түүнд үндэслэн заавар, зөвлөмжийг боловсруулан хүргүүлж, мөрдүүлэх замаар тухайн компанийн засаглалын түвшинг сайжруулахад оршино.

1.2. “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн зайны үнэлгээг компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс томилогдсон холбогдох эрх бүхий албан тушаалтан уг кодексийн нэгдүгээр хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлнэ.

1.3. Хөрөнгийн биржийн үнэт цаас гаргагч хариуцсан мэргэжилтэн нь компанийн ирүүлсэн зайны үнэлгээг баримтад үндэслэн хяналтын оноо болон хувь бүхий үнэлгээний нэгдсэн дүнг жилдтооцно.

1.4. Үнэлгээний нэгдсэн дүнг Хөрөнгийн биржийн үнэт цаасны ангилалд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй хувьцаат компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон компанийн засаглалын түвшингийн нэгдсэн судалгаа гаргаж олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.

1.5. Хөрөнгийн биржийн зүгээс “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилт, үнэлгээний нэгдсэн дүнг улирал тутмын эхний долоо хоногт Хороонд хүргүүлж, олон нийтэд мэдээллэнэ.

2. Үнэлгээний бүтэц

“Компанийн засаглалын кодекс”-ийн үнэлгээний загвар нь нийт 36 асуулга бүхий дараах бүтэцтэй тайлан байна. Үүнд:

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12			
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10			
3	Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6			
4	Аудит, хяналтын тогтолцоо	6			
5	Эрсдэлийн удирдлага	8			
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6			
7	Оролцогч талуудын эрх ашиг	8			
8	Компанийн соёл	6			
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10			
	Нэгдсэн дүн	72			

3. Үнэлгээний аргачлал

3.1. Асуулга тус бүрийн хувьд бүрэн хэрэгжүүлсэн, эсхүл үндэслэл бүхий тайлбар гаргасан 2, хэсэгчлэн хэрэгжүүлсэн, эсхүл хугацаа бүхий хэрэгжүүлэх арга хэмжээ, зорилтоо тайлбарласан 1, үнэлгээ ирүүлээгүй бол 0 гэсэн оноогоор тус тус үнэлэх ба хэрэгжилт болон тайлбарыг тус бүрээр нь оруулна.

3.2. Үнэлгээний нэгдсэн дүнд үндэслэн тухайн байгууллагын “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг дараах байдлаар үнэлнэ:

- 3.2.1.авбал зохих нийт онооны 90 хувь болон түүнээс дээш байвал засаглал хэвийн буюу эрсдэлгүй;
- 3.2.2.70-89 хувь байвал дунд засаглалтай буюу цаашид эрсдэл үүсч болзошгүй тул зөвлөмж хүргүүлэх;
- 3.2.3.50-69 хувь байвал хангалтгүй засаглалтай буюу эрсдэлтэй тул зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн;
- 3.2.4.49 болон түүнээс доош хувьтай бол муу засаглалтай буюу үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэй тул зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН

№	Гарчиг	Авбал зохих нийт оноо	Үнэлсэн оноо	Хяналтын оноо	Үнэлгээний хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12		
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10		
3	Тайлагнал, мэдээллийн илтгэл, байдал	6	6		
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	6		
5	Эрсдэлийн удирдлага	8	7		
6	Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5		
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	8		
8	Компанийн соёл	6	6		
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	10		
	Нэгдсэн дүн	72	70		97%

Дээрх хүснэгтэд үзүүлсэн дүнгээс харахад Монгол Даатгал ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 97% буюу хэвийн, эрсдэлгүй засаглалтай гэсэн үр дүнтэй гарсан байна.

**МОНГОЛ ДААТГАЛ ХК-ИЙН КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Компанийн засаглалын үнэлгээний асуулга					
<i>Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..</i>					
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ					
ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна					
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар	Оноо	Хувь
1	1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №1 тоот тогтоолоор батлан, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлтүүдийг хийж ажиллаж байна.	2	100%
2	1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 24/12 тоот тогтоолоор баталсан Залгамж халааны бодлого, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмаар зохицуулж байна.	2	100%
3	1.3. ТУЗ-ийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандаа байршуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд тусгасан. Компанийн цахим хуудаст байршуулсан.	2	100%
4	1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, дэргэдэх хороо тус бүрийн журмуудад тусгасан.	2	100%

5	1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийг шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Залгамж халааны бодлогод заасны дагуу хэрэгжүүлэн ажилладаг.	2	100%
6	1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмын дагуу хариуцлага хүлээдэг.	2	100%
ДҮН				12	100%
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ					
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ					
7	2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн тухай хуулийн 75.4-д заасантай нийцсэн.	2	100%
8	2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Аудит, хяналтын хорооны журам болон Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журмуудтай. Эдгээр зохицуулалт нь тус журмуудад тусгагдсан байгаа.	2	100%
9	2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмаар зохицуулдаг. Аудит, хяналтын хороо, Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх хороодын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүд ажилладаг ба гишүүдийн 2/3 нь мөн	2	100%

	хорооны хүсэлтээр оролцоно.		хараат бус гишүүд ажилладаг.		
10	2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Залгамж халааны бодлого, ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмаар зохицуулдаг.	2	100%
11	2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх Даатгалын эрсдэлийн хороог байгуулан ажиллаж байна.	2	100%
ДҮН				10	100%
ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ					
ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана					
12	3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах дотоод журмын дагуу зохицуулдаг.	2	100%
13	3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудасны “Хөрөнгө оруулагчдад” цэсэнд байршуулдаг.	2	100%
14	3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл	Бүрэн хэрэгжүүлсэн	Хагас жил, Жилийн эцсийн тайланд эдгээр мэдээллийг тусгадаг.	2	100%

	<i>ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</i>				
ДҮН				6	100%
ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО					
ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана					
15	<i>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	“Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-аар зохицуулж ажилладаг.	2	100%
16	<i>4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Аудитын хороо нь аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг. Мөн ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу ХЭЭХ-д хөндлөнгийн аудиторыг оролцуулахыг тусгасан.	2	100%
17	<i>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Жилийн эцсийн тайландаа тусгаж, цахим хуудсанд байршуулсан.	2	100%
ДҮН				6	100%
ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА					
ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина					
18	<i>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компани нь эрсдэлийн удирдлагын журамтай бөгөөд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах ажлын төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу шат дараатайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажилладаг.	2	100%
19	<i>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Эрсдэлийн удирдлагын чиг үүргийг ТУЗ-ийн дэргэдэх аудит,	2	100%

	байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.		хяналтын хороо болон Даатгалын эрсдэлийн хороод хариуцдаг. Аудитын хорооны дарга, гишүүдийн олонх нь хараат бус гишүүн мөн. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд хурлын давтамжийн талаар тайлагнадаг.		
20	5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	БОНЗ-ын тайландаа эдгээр мэдээллийг нэмж тусгахаар ажиллаж байна. Дуусмагц олон нийтэд мэдээлэх үүргийн дагуу хэрэгжүүлнэ.	1	100%
21	5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн 23/40 тоот тогтоолоор баталсан “Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”-өөр зохицуулдаг.	2	100%
ДҮН				7	87%
ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ					
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна					
22	6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.	Бүрэн хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар жил бүр ТУЗ-ийн жилийн зардлын төсвийг оруулж баталдаг бөгөөд ТУЗ-ийн гишүүний цалинг тусгадаг.	2	100%
23	6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журам болон цалин урамшууллын нэгдсэн бодлогоор зохицуулдаг.	2	100%

24	6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн	Залгамж халааны бодлого болон ТУЗ-ийн дэргэдэх засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журамд зохицуулалтыг нэмсэн. Цаашид тайланд тодорхой тусгаж ажиллана.	1	100%
ДҮН				5	83%
ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ					
Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ					
25	7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлогыг баримтлан ажилладаг.	2	100%
26	7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жилийн үйл ажиллагааны тайландаа тусгадаг.	2	100%
27	7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн цахим хуудсыг үр дүнтэй ажиллуулдаг.	2	100%
28	7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн дотоод журам, сургалт хөгжлийн тухай журмын дагуу хэрэгждэг. Гомдол, саналыг “Шүгэл үлээх суваг”-аар хүлээн авдаг.	2	100%
ДҮН				8	100%
НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ					
ТУЗ-ийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно					

29	8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.	Бүрэн хэрэгжүүлсэн	Ёс зүйн дүрмийг батлан хэрэгжүүлж ажиллаж байна.	2	100%
30	8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.	Бүрэн хэрэгжүүлсэн	“Шүгэл үлээх суваг”-ийг ажиллуулдаг. Цахим хуудаст зааврын хамт байршуулсан.	2	100%
31	8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.	Бүрэн хэрэгжүүлсэн	“Ёс зүйн дүрэм”-ээрээ зохицуулдаг.	2	100%
ДҮН				6	100%

ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

32	9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Жил, хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, цахим хуудсаар дамжуулан мэдээллээ тухай бүр хүргэж ажиллаж байна.	2	100%
33	9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.	Бүрэн хэрэгжүүлсэн	Цахим хуудаст компанийн ерөнхий мэдээлэл, үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг байршуулан ажилладаг. Мөн санал, гомдол хүлээн сувгийг ажиллуулж байна.	2	100%
34	9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл	Бүрэн хэрэгжүүлсэн	Хувьцаа эзэмшигчид хууль ёсны эрхээ эдлэх нөхцөл, боломжоор бүрэн хангагдсан.	2	100%

	<i>авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.</i>				
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасны дагуу эдгээр асуудлаар санал өгөх эрхээ хэрэгжүүлэх нөхцлөөр хангагдсан.	2	100%
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>	Бүрэн хэрэгжүүлсэн	ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.	2	100%
ДҮН				10	100%
НЭГДСЭН ДҮН				70	97%

Тайлан бэлтгэсэн:
ТУЗ-ийн НБД

Т.ЦАЦРАЛ

**“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

НОТЛОХ БАРИМТ БИЧГҮҮДИЙН ЖАГСААЛТ

1. Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр
2. Компанийн дүрэм
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
4. Дотоод хяналтын үйл ажиллагааны журам
5. Ногдол ашиг хуваарилалтын бодлого
6. Санхүүгийн тайланд аудит хийх хараат бус аудитын хуулийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам
7. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах журам
8. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам
9. Эрсдэлийн удирдлагын журам
10. Ёс зүйн дүрэм
11. Дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр
12. Залгамж халааны бодлого
13. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журам
14. Аудит, хяналтын хорооны журам
15. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журам
16. Оролцогч талуудтай харилцах хөтөлбөр
17. 2023 оны Компанийн үйл ажиллагааны тайлан
18. 2023 оны ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан
19. 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал